

БИ МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАГШ БАЙСАН

Ч. МИНЖИН

ШУТИС, Геологи-Газрын тосны сургууль

Оришил

Миний ажил, амьдралын гараа Монгол улсын их сургуулиас эхэлсэн юм. Би 1967 онд Москвагийн их сургуулийг геологи-палеонтологийн мэргэжлээр төгсөөд шууд МУИС-ийн Геологийн салбарт багшаар орж ажилласан. Намайг багш болгон амьдралын замд хөтөн бүр гольдролд нь оруулж өгсөн Ж.Лхамсүрэн багшдаа баярлаж явдаг. Манай Геологийн салбарын харьяалал байнга өөрчлөгдөж байсан ч бидний сургалт, судалгааны ажил тэлж, гүнзгийрэн хөгжсөөр одоо ШУТИС-ийн бүрэлдэхүүнд хэд хэдэн салбартай бие даасан сургууль болтолоо хөгжив. Анх МУИС-ийн харьяанд байгуулагдсан Политехникийн дээд сургууль хөгжин томорсоор 1982 онд бие даан гараад нь түүний бүрэлдхүүнд байсан манай Геологийн салбар хамт энэхүү их сургуулиас гарсан түүхтэй юм. Ийнхүү миний бие 1967-1982 онуудад албан ёсоор МУИС-ийн багш нь байлаа. Би эндээс л сургалтын ажлын дадлага туршлагатай болсон, судалгаа шинжилгээгээ эхлэн эрдмийн зэрэг хамгаалсан, гэр бүл, үр хүүхдүүдтэй болж тэднийг өсгөж бойжуулсан, бие даан амьдрах болсоон. Би энэ дурсамжинд багш болж буй үеээс сэтгэлд үлдсэн зарим баримтыг өгүүлж байна.

Анхны жилүүд

Миний багш болох үед манай Геологийн салбар дөнгөж бүрэлдэн тогтох 1963, 1965, 1966, 1967 онуудад нийт 4 удаагийн төгсөлт хийсэн байлаа. Багш нар нь шинэ, залуухан, зарим багш нар шилжин явж байсан үе. Тухайлбал палеонтологийн багш Р.Барсболд, Б.Мэндбаяр, геологийн багш О.Төмөртогоо нар ШУА-ийн Геологийн хүрээлэнд шилжсэн ба шилжих байв. Эхний жилүүдэд манай салбар бие даан хөгжихэд Зөвлөлтийн мэргэжилтэн багш нарын туслалцаа дэмжлэг их үүрэг гүйцэтгэсэн гэж боддог. Ер нь Зөвлөлтийн геологчид, мэргэжилтэн бэлтгэдэг туршлага нь бидний мөрдөх жишиг нь байлаа. Миний багш болсон үед геологийн салбар нь Ерөнхий геологи ба Минералоги-петрографи гэсэн хоёр тэнхимтэй Геологи-газарзүйн факультетэд харьялагдах болж байв. Манай Ерөнхий геологийн тэнхимиин эрхлэгч Ж. Ган-Очир, багш нар нь Я.Болд, Б.Ишмэнд бид нар байв (Зураг 1). Бүгд залуу, туршлага үгүй ч зоригтой, оюутнуудаасаа ялгарахгүй ч дотроо багш гэж өөртөө итгэсэн нөхөд байж билээ. Ер нь сонирхуулан тэмдэглэхэд Геологийн тэнхимээс л Минералоги-петрографи, Ашигт малтмал хайгуул, Гидрогеологи, Уул уурхай, Гидрогеологи зэрэг тэнхимүүд тасран гарч улмаар бие даасан факультет, сургууль үүссэн түүхтэй.

Анх би “Регионал геологийн” хичээл зааж эхлээд цаашдаа “Палеонтологи”, “Түүхэн геологи” дагнан заах болов. Зарим тохиолдолд “Дөрөвдөгчийн геологи, “геоморфологийн” хичээл заадаг байлаа. Түүнээс гадна 2-р курсийн дараах “Геологийн зураглалын дадлага” 2 удаа удирдсан. Ер нь олон өөр хичээл заахад хэцүү ч мэдлэгийн хүрээ тэлдэг сайн талтай. Цөөн хичээл дагнан заахад мэдлэг гүнзгийрэн, туршлагаждаг гэж боддог. Түүхэн геологийн хичээл олон жил зааснаар стратиграф, палеогеограф, тектоникийн чиглэлээр мэдлэг тэлэн улмаар судалгааны ажил хийхэд их тус болсон. Палеонтологийн хичээл миний биологийн ухааны үндсэн ойлголтыг гүнзгийрүүлэв.



Зураг 1. Ерөнхий геологийн тэнхимиийн багш Ч.Минжин, Я.Болд,
эрхлэгч Ж.Ган-Очир(зүүнээс)

Геологийн зураглалын дадлага

1968 оны зураглалын дадлага удирдах ажил миний хичээлийн ачаалалд орсон учир хавар эрт тэнхимиийн эрхлэгч Ж.Ган-Очир Өрмөгтэйн дадлагын полигоныг надад танилцуулув. Дархан хот ба Шарын голын нүүрсний уурхайн хооронд буй полигон гэхээр л би өнөө Крым дэх Москвагийн их сургуулийн дадлагын полигон мэтээр ойлголт авсан хүн очиж үзэв. Гэтэл энд дадлагын полигон гэж байгуулсан юм юу ч алга, зөвхөн байгаль, Өрмөгтэй уул, дэргэдүүр нь урсах Шарын гол, бас эндээс нилээд зйтай Дэл-Бунхан хэмээх толгодын талбай үзэв. Хаагуур маршрут хийж, юу

үздэг болохыг Ган-Очир маань хэлж өгөв. Эндэх дадлагаар Өрмөгтэй уулын доод карбоны фаунтай тэнгисийн шельфийн зүсэлт хийж геологийн зураг зохиох сургалтын үндсэн ажил, Дэл-Бунхан толгодын зүсэлт, Бугантын алтны, Шарын голын нүүрсний Төмөрт толгойн ордуудыг үзэх ёстойг ойлгож авав. Дадлага хийх хугацаа нь болж би 2-р курсийн 30aad оюутныг ачааны том машины тэвшинд суулгаад хотоос гарав. Бидний хангамж монгол майхан, төмөр зуух, яндан, ширмэн тогоо (Зураг 2) болон тампуу гурил, ногоон цай, элсэн чихэр, давс, нилээд хэмжээний оросын тушенк консерв, талх зэрэг... Ус, түлээ нутгаас үнэгүй... Аяга, таваг, хөнжил гудас, даавуу, хувцас зэрэг нь оюутнуудын хувийн өмч. Бас хүн бүр өөрсдийн нандин юмсаа хийдэг цоожтой жижиг модон авдартай.



Зураг 2. 1968 оны Өрмөгтэйн геологийн зураглалын дадлагын полигон

Урд нь энд дадлага хэн нь хэрхэн явуулж байсныг би огт мэдэхгүй шинэ хүн. Миний туршлага гэвэл геологийг ойлгож эхэлсэн бас дуртай болгосон 1964 оны Крымд хийсэн зураглалын дадлага. Дараа нь 1967 оны хавар би дахин Крымын полигонд ирж зураглалын дадлага хийлгэх, удирдахаар судалсан туршлага. Түүнээс гадна 1965 онд Хөвсгөлийн Дархадын хотгорын тойронд А.В.Ильиний удирдсан 1:500 000 масштабтай зураглалын ангид хийсэн үйлдвэрлэлийн анхдугаар дадлага, 1966 оны Дорнодын Баян-Уулын нутагт В.А.Благонравов удирдсан 1:200 000 масштабтай зураглалын ангид хийсэн дипломын өмнөх дадлага зэрэг байлаа. Бас ч хоосонгүй. Би хэдийгээр дадлага удирдаж байгаагүй ч яаж хийх тухай өөрийн төсөөлөлтэй, бас зориг, тэмүүлэлтэй хүн ирлээ. Энэ дадлагаар оюутнууддаа геологийн зураглал хийх арга, ажлын анхан шатны ойлголт өгсөн гэж боддог. Бас Шарын голын нүүрсний уурхай үзүүлж, түүний үйл ажиллагааг нь залуу инженер П. Очирбатаар

тайлбарлуулав. Дадлагыг хагас цэрэгжүүлсэн байдалд, цагийн хуваарь хатуу сахиулан хийлгэх тул чөлөө цаг бага, элдэв зөрчил гараагүй. Дадлагаа хөтөлбөрийн дагуу хийж тайлан бичүүлж хамгаалаад буув. Дараа жил нь бүр цөөхөн оюутантай анги аваад дахиад л энэ зураглалын дадлагад гарах үед манай тэнхимийн эрхлэгч Ган-Очир тэр жил төгссөн тамирчин байрын нэг залууг дагуулан ирж, манай зураглалын шинэ багш Чулуун гэж танилцуулаад дадлага удирдахыг зааж өгөх үүрэг өгөв.



Зураг 3. 1969 оны дадлага. Өглөөний шугам жагсаал

Шинэ багш дуулгавартай, бүх ажилд идэвхитэй оролцох тул надад их тус болсон (Зураг 3). Би түүнд дадлага удирдахад шаардагдах геологийн зураглалын ба зохион байгуулалтын талаарх арга, туршилагаас зааж өгөв. Цаашид Чулуун багш энэ дадлагыг одоо хүртэл удирдан явна. Энэ хугацаанд нь би зураглалын дадлагаар оюутнуудад их зүйл сургах боломжтой Монголын геологийн сонгодог зүсэлтүүдтэй Мушгай худаг, Шинэжинст зэргийг Чулуун багшид үзүүлэн танилцуулж билээ. Дадлагаа ч хийсэн байх. Цаашид би энэ дадлагад тун бага оролцов. Учир нь дадлага хийдэг зуны саруудыг би өөрийн хээрийн судалгаанд зарцуулав. Тэгээд ч миний сургалтын ачаалал дадлага удирдахгүйгээр хүрэлцээтэй байлаа.

Палеонтологийн сургалтын бааз

1962 оны зун би 10-р ангия төгсөөд ЗХУ-д сургуульд явах хуваар্তай хүн Сүхбаатарын талбай дээр нутгийн ах Г.Батжаргалтай уулздаг юм байна. Тэрээр МУИС-д геологийн салбарт лаборант хийдэг гэнэ. Юм мэдэхгүй би багш мэтээр ойлгов. Намайг геологийн мэргэжлээр ЗХУ-д сургууль явахыг сонсоод тэр өөрийн хариуцдаг кабинетаа үзүүлэхээр дагуулан шууд л МУИС дээр ирэв. Кабинетэд нь дан

чулуу биш бас эртний амьтдын үлдэгдэл гээд сонин юмс их бий гэнэ. Амралтын өдөр байсан тул өрөөнүүд цоожтой, өнөө кабинетын түлхүүр нь олдоогүй, орж чадсангүй. Батжаргал ах харамсан гадаа нь гарч баруун гудамж талаас нэгдүгээр давхарын цонхоор юм харуулах гэсэн ч олигтой юм болсонгүй өнгөрөв. Ингээд энэ хэрэг өнгөрөв. Үнэндээ би ч нэг их харамсан ч үгүй. Гэтэл сүүлд Ж.Лхамсүрэн багш, Р. Барсболд гуайгаас мэдсэн чинь тэр кабинет 1967 онд би МУИС-д багш болоод хариуцан авч сургалт, судалгаагаа явуулсан палеонтологийн кабинетын эх үүсвэр нь байжээ. 1967 онд Геологийн салбар МУИС-ийн хичээлийн 2-р байранд нүүж орсон тул өнөө кабинет ч энд ирсэн байв. Ингээд миний амьдралын бүх хугацаа энэ кабинеттэй холбоотой явж ирэв. Энэ кабинетэд урд нь ЗХУ-аас захиалж ирүүлсэн сургалтын бүрэн, цогц үзүүлэнг палеонтологи, түүхэн геологийн хичээлийн сургалтанд ашиглаж байв. Дараа нь би дахиад үзүүлэнг Ленинградаас захиалан авчуулав. Аажмаар кабинетаа Монголынхоо палеонтологийн материалаар баяжуулан сургалтанд ашиглах болов. Түүнээс гадна энд геологи, палеонтологийн сургалтанд зориулсан номын сан, сэдэвт судалгааны материал хадгалагдаж, багш нар эрдэм шинжилгээний ажлаа хийх, оюутнуудыг палеонтологоор мэргэшүүлэх сургалт явагдаж байна. Одоо ШУТИС-ийн Геологи газрын тосны сургуулийн 222-р өрөөнд байгаа энэ кабинетийг миний шавь, доктор Г.Сэргсмаа багш хариуцан сургалт, судалгааны ажил амжилттай явуулж байна.



Зураг 4. 1969 он. Өмнөговь, Баянзаг. Ч.Минжин, Нармандах, Ё.Ханд, оюутан Банзрагч, А.Пэрлээ (зүүнээс баруун тийш)

Миний багш болсон жил 5-р курсийн оюутан Алтангэрэлийн Пэрлээ ирж уулзdag байлаа. Оюутан А.Пэрлээ палеонтологи сонирхон энэ чиглэлээр мэргэших зорилготой ч энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх бодит бололцоо тэр үед хэцүү байлаа. Гэвч А.Пэрлээ өөрийн оролдлого, зүтгэлээр англи хэл бие даан сурч, улмаар Монгол-Зөвлөлтийн палеонтологийн экспедицийн судалгаанд идэвхитэй оролцон сээр нууутны палеонтологич болж чадсан байна (Зураг 4). А.Пэрлээ Монголын динозаврыг олон жил амжилттай судлан эрдмийн зэрэг хамгаалан, олон бүтээл хэвлүүлсэн байна. МУИС-ийн бүрэлдэхүүнд дахин байгуулагдсан Геологийн салбарт А.Пэрлээ багш палеонтологийн сургалт, судалгааг удирдан зохион байгуулсан юм.